

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/327/НА-СТА-ТШЗ

| | |
|---|--|
| Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он | Санхүү-нийцлийн газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас:Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ц.Хосжаргал Утас:Цахим хаяг: khosjargalts@audit.gov.mn Ахлах аудитор: В.Эрдэнэцогт Утас:Цахим хаяг: erdenetsogtb@audit.gov.mn Аудитор С.Отгонхорлоо Утас:Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хог, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/316
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 53,622.6 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд санхүүгийн тайлагналын иж бүрэн, оршин байх, толилуулга, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 122,071.7 мянган төгрөгийн бараа материалын тооллого хийгээгүй;
- Нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулахгүйгээр 310,675.5 мянган төгрөгөөр байрны их засварын ажлыг шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн, барилгын өртгийг капиталжуулаагүй

зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Нягтлан бодох бүртгэлийн 12 дугаар зүйлийн 12.2, Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д гэж заасантай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 64 дүгээр тушаалаар баталсан удирдамжийн дагуу зарим төрийн байгууллага, сумын

захиргааны байгууллагад процессын дахин инженерчлэл хийх удирдамжийн дагуу баруун, төвийн, зүүн бүсүүдэд сургалт, судалгаа хийхэд 22,397.2 мянган төгрөгийн төсвийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь нийгмийн даатгалын багц хуулийн хэлэлцүүлэг, бүтээгдэхүүн үйлчилгээний цахим систем нэвтрүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх сангийн программтай холбоотой Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны А/163 тушаалаар 52,356.5 мянган төгрөгийн төсөв баталж, цахим сургалтыг зохион байгуулж, сургагч багш бэлтгэж, төв, орон нутгийн хэлтсийн бусад ажилтнуудад сургалт зохион байгуулан ажилласан байна.

Засгийн газрын 2023 оны “Итгэлцүүр шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 238 дугаар, “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 239 тогтоолуудын хэрэгжилтийг зохион байгуулж, нийслэл, дүүргүүд болон төв, орон нутгийн хэлтсүүдэд 487 мянган иргэдийн хувийн хэргийн шинэчлэх ажлыг зохион байгуулахад төсвөөс 33,082.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардал зарцуулжээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар
болсон /төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|--------|---|------------------|------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 145,374,804.02 | 124,952,733.55 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,175,720.24 | 1,820,683.40 |
| 31200 | Банканд байгаа бэлэн мөнгө | 1,175,720.24 | 1,820,683.40 |
| 31210 | Төгрөг | 1,175,720.24 | 1,820,683.40 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | 376.25 |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | 196,107.15 | 196,107.15 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 979,613.09 | 1,624,200.00 |
| 33 | АВЛАГА | 4,432,500.61 | 1,060,347.98 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 326,167.98 |
| 33500 | Бусад авлага | 4,432,500.61 | 734,180.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 3,718,030.61 | 19,710.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 714,470.00 | 714,470.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 139,766,583.17 | 122,071,702.17 |
| 35400 | Хангамжийн материал | 139,766,583.17 | 122,071,702.17 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 20,462,409.99 | 3,978,371.99 |
| 35420 | Аж ахуйн материал | 43,798,806.18 | 57,210,771.18 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,648,900.00 | 7,584,960.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 71,856,467.00 | 53,297,599.00 |
| 3695 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 5,508,580,813.49 | 5,348,181,163.57 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 5,508,580,813.49 | 5,348,181,163.57 |
| 39200 | Биет хөрөнгө | 5,375,643,118.48 | 5,252,028,682.72 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,048,823,653.14 | 5,031,944,551.54 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (342,072,535.51) | (402,466,184.38) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 89,064,000.00 | 62,070,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (18,730,294.88) | (10,380,294.92) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 857,870,213.96 | 807,712,654.48 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (325,847,933.40) | (415,633,665.59) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 331,189,483.70 | 429,569,789.93 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (264,653,468.53) | (250,788,168.34) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 132,937,695.01 | 96,152,480.85 |
| 39301 | Программ хангамж | 37,828,278.00 | 33,808,879.60 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (32,769,339.59) | (31,499,486.95) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 161,914,425.00 | 161,914,425.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (34,035,668.40) | (68,071,336.80) |
| 395 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 5,653,955,617.51 | 5,473,133,897.12 |
| 40 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 722,061.79 | 1,793,452.17 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 722,061.79 | 1,793,452.17 |
| 41300 | Өглөг | 722,061.79 | 1,793,452.17 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 498,251.79 | 155,442.17 |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | 50,000.00 | 50,000.00 |
| 41360 | Бусад өглөг | 173,810.00 | 1,588,010.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 173,810.00 | 1,588,010.00 |
| 50 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 5,653,233,555.72 | 5,471,340,444.95 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,653,233,555.72 | 5,471,340,444.95 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,130,919,957.98 | 2,130,919,957.98 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 2,130,919,957.98 | 2,130,919,957.98 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,834,686,806.02 | 1,652,793,695.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,834,686,806.02 | 1,834,686,806.02 |

| | | | |
|-------|--|------------------|------------------|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (181,893,110.77) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,687,626,791.72 | 1,687,626,791.72 |
| 60 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 5,653,955,617.51 | 5,473,133,897.12 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар
болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|--|------------------|------------------|
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 3,209,967,288.09 | 5,180,367,466.56 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 108,270,261.57 | 153,214,322.56 |
| Нийтлэг татварын бус орлого | 108,270,261.57 | 153,214,322.56 |
| Хүүгийн орлого | - | 376.25 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 108,270,261.57 | 42,361,392.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 108,270,261.57 | 42,361,392.00 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 110,852,554.31 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,101,697,026.52 | 5,027,153,144.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 89,125,172.00 | 210,000.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 88,180,172.00 | - |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 945,000.00 | 210,000.00 |
| Төсвийн захирагчдаас | 374,433,154.52 | 85,715,544.00 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 374,433,154.52 | 85,715,544.00 |
| Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 2,638,138,700.00 | 4,941,227,600.00 |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,904,387,100.00 | 4,941,227,600.00 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 733,751,600.00 | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,149,366,368.89 | 5,362,260,577.33 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 3,149,366,368.89 | 5,362,260,577.33 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,766,695,494.90 | 4,097,663,515.24 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,707,941,781.15 | 2,441,750,006.37 |
| Үндсэн цалин | 1,060,143,953.06 | 1,275,128,464.64 |
| Нэмэгдэл | 307,394,482.37 | 488,059,868.96 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 158,595,000.00 | 232,342,000.00 |
| Урамшуулал | 181,808,345.72 | 446,219,672.77 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 213,745,951.47 | 304,507,259.39 |
| Тэтгэврийн даатгал | 149,227,754.74 | 210,966,499.19 |
| Тэтгэмжийн даатгал | 17,039,628.24 | 24,814,411.92 |
| ҮОМШӨ-ний даатгал | 13,260,975.08 | 19,583,129.40 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,070,442.62 | 4,383,406.34 |
| Эрүүл мэндийн даатгал | 31,147,150.79 | 44,759,812.54 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,636,127.12 | 46,714,841.12 |
| Гэрэл, цахилгаан | 21,266,523.73 | 26,980,101.37 |
| Түлш, халаалт | 8,820,148.39 | 12,642,808.75 |
| Цэвэр, бохир ус | 6,549,455.00 | 7,091,931.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 85,321,115.63 | 109,593,362.00 |
| Бичиг хэрэг | 24,865,973.00 | 18,662,878.00 |
| Тээвэр, шатахуун | 6,790,960.00 | 1,699,100.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,906,483.63 | 21,610,900.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,070,000.00 | 1,058,000.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 32,687,699.00 | 33,728,192.00 |
| Бараа материал акталсны зардал | - | 32,834,292.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 24,519,405.00 | 325,907,834.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 8,331,500.00 | 15,232,287.00 |

| | | |
|--|-----------------------|-------------------------|
| Урсгал засвар | 16,187,905.00 | 310,675,547.00 |
| Томилолт, зочны зардал | 93,833,850.00 | 96,159,073.00 |
| Дотоод албан томилолт | 93,833,850.00 | 96,159,073.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 201,221,501.00 | 318,954,819.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 197,311,420.00 | 313,558,573.00 |
| Даатгалын үйлчилгээ | 570,240.00 | 2,079,930.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 482,229.00 | 260,993.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 750,000.00 | - |
| Газрын төлбөр | - | 808,088.00 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 125,420.00 | 134,430.00 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,982,192.00 | 2,112,805.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 403,475,763.53 | 454,076,320.36 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 12,120,500.00 | - |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 97,103,743.00 | 118,396,789.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 294,251,520.53 | 335,679,531.36 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 382,670,873.99 | 1,264,597,062.09 |
| Бусад урсгал шилжүүлэг | 165,525,512.00 | 124,204,535.63 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 66,054,152.00 | 62,198,422.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 62,123,235.00 | 62,006,113.63 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 37,348,125.00 | - |
| Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 217,145,361.99 | 1,140,392,526.46 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 217,145,361.99 | 1,140,392,526.46 |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (I)-(II) | 60,600,919.20 | (181,893,110.77) |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 28,822,500.00 | - |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 28,822,500.00 | - |
| ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 31,778,419.20 | (181,893,110.77) |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон /төгрөгөөр/

| Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|--|-------------------------|-------------------------|
| ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО | 2,851,843,618.09 | 5,013,402,496.25 |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 108,270,261.57 | 70,550,696.25 |
| Нийтлэг татварын бус орлого | 108,270,261.57 | 70,550,696.25 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 108,270,261.57 | 70,550,696.25 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 108,270,261.57 | 70,550,696.25 |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,743,573,356.52 | 4,942,851,800.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 89,125,172.00 | 1,624,200.00 |
| Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 88,180,172.00 | 1,414,200.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 945,000.00 | 210,000.00 |
| Төсвийн захирагчдаас | 16,309,484.52 | - |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 16,309,484.52 | - |
| Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 2,638,138,700.00 | 4,941,227,600.00 |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,904,387,100.00 | 4,941,227,600.00 |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 733,751,600.00 | - |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,880,624,853.02 | 5,012,757,533.09 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,880,624,853.02 | 5,012,757,533.09 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,578,835,298.64 | 3,933,234,423.87 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,707,353,616.30 | 2,442,377,709.65 |
| Үндсэн цалин | 1,204,358,589.29 | 1,300,860,852.60 |
| Нэмэгдэл | 218,690,303.07 | 504,282,832.47 |

| | | |
|--|-----------------|------------------|
| Унаа хоолны хөнгөлөлт | 98,184,822.57 | 214,519,754.29 |
| Урамшуулал | 186,119,901.37 | 422,714,270.29 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 221,251,644.99 | 300,850,213.10 |
| Тэтгэврийн даатгал | 153,824,291.38 | 207,309,452.90 |
| Тэтгэмжийн даатгал | 17,116,078.71 | 24,814,411.92 |
| ҮОМШӨ-ний даатгал | 13,645,542.86 | 19,583,129.40 |
| Ажилгүйдлийн даатгал | 3,293,091.52 | 4,383,406.34 |
| Эрүүл мэндийн даатгал | 33,372,640.52 | 44,759,812.54 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 36,636,127.12 | 46,714,841.12 |
| Гэрэл, цахилгаан | 21,266,523.73 | 26,980,101.37 |
| Түлш, халаалт | 8,820,148.39 | 12,642,808.75 |
| Цэвэр, бохир ус | 6,549,455.00 | 7,091,931.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 96,567,439.63 | 148,625,346.00 |
| Бичиг хэрэг | 39,247,843.00 | 67,945,800.00 |
| Тээвэр, шатахуун | 6,790,960.00 | 1,699,100.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 19,906,483.63 | 21,610,900.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,070,000.00 | 1,058,000.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 29,552,153.00 | 56,311,546.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 26,545,405.00 | 407,176,438.00 |
| Багаж, техник, хэрэгсэл | 10,357,500.00 | 96,500,891.00 |
| Урсгал засвар | 16,187,905.00 | 310,675,547.00 |
| Томилолт, зочны зардал | 93,833,850.00 | 96,159,073.00 |
| Дотоод албан томилолт | 93,833,850.00 | 96,159,073.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 259,479,309.00 | 372,934,014.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 197,311,420.00 | 313,558,573.00 |
| Даатгалын үйлчилгээ | 570,240.00 | 2,079,930.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 482,229.00 | 260,993.00 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 750,000.00 | - |
| Газрын төлбөр | - | 808,088.00 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 125,420.00 | 134,430.00 |
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 60,240,000.00 | 56,092,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 136,392,468.76 | 118,396,789.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 34,668,725.76 | - |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 101,723,743.00 | 118,396,789.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 302,564,992.22 | 1,079,523,109.22 |
| Бусад урсгал шилжүүлэг | 165,525,512.00 | 124,204,535.63 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 66,054,152.00 | 62,198,422.00 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 62,123,235.00 | 62,006,113.63 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 37,348,125.00 | - |
| Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 137,039,480.22 | 955,318,573.59 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 137,039,480.22 | 955,318,573.59 |
| ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (28,781,234.93) | 644,963.16 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (28,781,234.93) | 644,963.16 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 29,956,955.17 | 1,175,720.24 |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,175,720.24 | 1,820,683.40 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| 2021 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,806,257,945.58 | 5,624,804,695.28 |

| | | | | |
|---|------------------|------------------|------------------|------------------|
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | (3,349,558.76) | (3,349,558.76) |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,802,908,386.82 | 5,621,455,136.52 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | 31,778,419.20 | 31,778,419.20 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,834,686,806.02 | 5,653,233,555.72 |
| 2023 оны 01-р сарын 01-нээрх эхний үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,834,686,806.02 | 5,653,233,555.72 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,834,686,806.02 | 5,653,233,555.72 |
| Тайлант үеийн үр дүн | - | - | (181,893,110.77) | (181,893,110.77) |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,130,919,957.98 | 1,687,626,791.72 | 1,652,793,695.25 | 5,471,340,444.95 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|------------------|------------------|------------------|-------|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,111,227,600.00 | 4,056,459,346.41 | 1,054,768,253.59 | 79.4 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 5,111,227,600.00 | 4,056,459,346.41 | 1,054,768,253.59 | 79.4 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,981,265,900.00 | 3,932,254,810.78 | 1,049,011,089.22 | 78.9 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,119,057,500.00 | 2,441,398,096.56 | 677,659,403.44 | 78.3 |
| Үндсэн цалин | 1,447,470,400.00 | 1,300,860,852.60 | 146,609,547.40 | 89.9 |
| Нэмэгдэл | 905,687,100.00 | 504,282,832.47 | 401,404,267.53 | 55.7 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 293,598,800.00 | 214,519,754.29 | 79,079,045.71 | 73.1 |
| Урамшуулал | 472,301,200.00 | 421,734,657.20 | 50,566,542.80 | 89.3 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 530,043,200.00 | 300,850,213.10 | 229,192,986.90 | 56.8 |
| Тэтгэврийн даатгал | 357,229,900.00 | 207,309,452.90 | 149,920,447.10 | 58.0 |
| Тэтгэмжийн даатгал | 43,203,600.00 | 24,814,411.92 | 18,389,188.08 | 57.4 |
| ҮОМШӨ-ний даатгал | 34,562,800.00 | 19,583,129.40 | 14,979,670.60 | 56.7 |
| Ажилгүйдлийн даатгал | 8,640,800.00 | 4,383,406.34 | 4,257,393.66 | 50.7 |
| Эрүүл мэндийн даатгал | 86,406,100.00 | 44,759,812.54 | 41,646,287.46 | 51.8 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50,182,800.00 | 46,714,841.12 | 3,467,958.88 | 93.1 |
| Гэрэл, цахилгаан | 28,937,500.00 | 26,980,101.37 | 1,957,398.63 | 93.2 |
| Түлш, халаалт | 13,810,400.00 | 12,642,808.75 | 1,167,591.25 | 91.5 |
| Цэвэр, бохир ус | 7,434,900.00 | 7,091,931.00 | 342,969.00 | 95.4 |
| Хангамж, бараа материалын зардал | 158,944,300.00 | 148,625,346.00 | 10,318,954.00 | 93.5 |
| Бичиг хэрэг | 67,945,800.00 | 67,945,800.00 | - | 100.0 |
| Тээвэр, шатахуун | 4,937,600.00 | 1,699,100.00 | 3,238,500.00 | 34.4 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 21,610,900.00 | 21,610,900.00 | - | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,700,000.00 | 1,058,000.00 | 4,642,000.00 | 18.6 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 58,750,000.00 | 56,311,546.00 | 2,438,454.00 | 95.8 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 468,961,500.00 | 407,176,438.00 | 61,785,062.00 | 86.8 |
| Багаж, техник, хэрэгсэл | 111,491,500.00 | 96,500,891.00 | 14,990,609.00 | 86.6 |
| Урсгал засвар | 357,470,000.00 | 310,675,547.00 | 46,794,453.00 | 86.9 |
| Томиллолт, зочны зардал | 97,424,100.00 | 96,159,073.00 | 1,265,027.00 | 98.7 |
| Дотоод албан томиллолт | 97,424,100.00 | 96,159,073.00 | 1,265,027.00 | 98.7 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 398,476,500.00 | 372,934,014.00 | 25,542,486.00 | 93.6 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 328,357,200.00 | 313,558,573.00 | 14,798,627.00 | 95.5 |
| Даатгалын үйлчилгээ | 4,000,000.00 | 2,079,930.00 | 1,920,070.00 | 52.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 500,000.00 | 260,993.00 | 239,007.00 | 52.2 |
| Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 328,600.00 | - | 328,600.00 | - |
| Газрын төлбөр | 2,000,000.00 | 808,088.00 | 1,191,912.00 | 40.4 |
| Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | 570,000.00 | 134,430.00 | 435,570.00 | 23.6 |

| | | | | |
|---|------------------|------------------|------------------|-------|
| Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 62,720,700.00 | 56,092,000.00 | 6,628,700.00 | 89.4 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 158,176,000.00 | 118,396,789.00 | 39,779,211.00 | 74.9 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 158,176,000.00 | 118,396,789.00 | 39,779,211.00 | 74.9 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 129,961,700.00 | 124,204,535.63 | 5,757,164.37 | 95.6 |
| Бусад урсгал шилжүүлэг | 129,961,700.00 | 124,204,535.63 | 5,757,164.37 | 95.6 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 65,374,800.00 | 62,198,422.00 | 3,176,378.00 | 95.1 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 63,586,900.00 | 62,006,113.63 | 1,580,786.37 | 97.5 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | - | 1,000,000.00 | - |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 5,111,227,600.00 | 4,056,459,722.66 | 1,054,767,877.34 | 79.4 |
| НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 4,941,227,600.00 | 4,015,234,578.41 | 925,993,021.59 | 81.3 |
| Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 4,941,227,600.00 | 4,015,234,578.41 | 925,993,021.59 | 81.3 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 170,000,000.00 | 41,225,144.25 | 128,774,855.75 | 24.3 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 170,000,000.00 | 41,225,144.25 | 128,774,855.75 | 24.3 |
| Төсвийн байгууллага | 1 | 1 | | |
| АЖИЛЛАГСДЫН ТОО | 101 | 87 | 14 | 86.1 |
| Удирдах ажилтан | 11 | 9 | 2 | 81.8 |
| Гүйцэтгэх ажилтан | 83 | 71 | 12 | 85.5 |
| Үйлчлэх ажилтан | 7 | 7 | 0 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
|--------|--|------------|--------------|
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 979,613.09 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 979,613.09 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 979,613.09 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 979,613.09 |
| 210104 | Урамшуулал | | 979,613.09 |
| 1 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | 1,624,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 1,624,200.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан | | 1,414,200.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 210,000.00 |
| 3 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | 644,586.91 |
| 9 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 979,613.09 |
| 10 | Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,624,200.00 |

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 514,340.2 мянган төгрөгийн 9 зөрчил¹ илэрснээс, 373,694.5 мянган төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 140,645.7 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн. Хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|-------------|-----------|---------------|-----|-----------------|-----------|---------|-----------|--------------------------------------|---------------------|---|-----|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Харьяа байгууллага болох Мэдээлэл технологийн төвөөр 9,500.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгүүлж, холбогдох байгууллагын шийдвэргүйгээр шилжүүлэн авсан. | 1 | 9,500.0 | | | | | 1 | 9,500.0 | | | | |
| Жилийн эцсийн тооллого хийхдээ 122,071.7 мянган төгрөгийн бараа материалыг тооллогын комиссын шийдвэрт тусгаагүй, үр дүнг хэлэлцээгүй, эд хариуцагч нар бараа материалыг жагсаалтаар ажил хүлээлцсэн. | 1 | 122,071.7 | | | | | 1 | 122,071.7 | | | | |
| Бараа худалдан авах аргыг сонгох босго үнийг баримтлалгүй 24,010.0 мянган төгрөгийн бичгийн цаас худалдах авах ажиллагааг харьцуулалтын аргаар бус шууд худалдан авсан. | 1 | 24,010.0 | | | 1 | 24,010.0 | | | | | | |
| Тайлант онд хөрөнгө оруулалт болон худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй бараа ажил үйлчилгээ гүйцэтгэж, нээлттэй тендер сонгон шалгаруулаагүй, хэсэгчлэн хуваан 8 аж, ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж, 310,675.5 мянган төгрөгийн барилгын засварын ажил гүйцэтгэсэн | 1 | 310,675.5 | | | 1 | 310,675.5 | | | | | | |

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|--|----------|------------------|----------|----------|----------|------------------|----------|------------------|----------|----------|----------|----------|
| Сургалтын зардлаас зөвлөгөөн болон тайлангийн хурал зохион байгуулахад 23 удаа сургалт зохион байгуулснаас 39,009.0 мянган төгрөгийг хоолны зардалд зарцуулсан. | 1 | 39,009.0 | | | 1 | 39,009.0 | | | | | | |
| ММНБИ-ээс зохион байгуулсан сургалтад 10 албан хаагчийг 2 удаа хамруулж 3,874.0 мянган төгрөгийг төсвөөс төлсөн, анхан шатны бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрсөн. | 1 | 3,874.0 | | | | | 1 | 3,874.0 | | | | |
| Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын буцалтгүй тусламжийн А/181 тушаалаар албан хаагчдад тэтгэмж урамшууллын зардлаас заалны түрээсийн төлбөрийг шилжүүлсэн. | 1 | 5,200.0 | | | | | 1 | 5,200.0 | | | | |
| Туслах үйл ажиллагааны орлогыг 128,774.8 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлсэн нь өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Орон тоонд өөрчлөлт ороогүй, төсөв батлагдаагүй, гэрээт 5-н ажилтны цалин, шимтгэлд нийт 91,638.6 мянган төгрөгийг тус тус олгосон байгаа нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаагүй. | 1 | - | | | | | | | 1 | - | | |
| Дүн | 9 | 514,340.2 | - | - | 4 | 373,694.5 | 4 | 140,645.7 | 1 | - | - | - |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар бусад хууль тогтоомжтой холбоотой 1 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | |
|--------------------|-------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Өмнөх оноос НДС-аас санхүүжүүлж байгаа үйл ажиллагааны зардлын гүйцэтгэл 57.2 хувиар өссөн байна. Иймд холбогдох эрх зүйн актуудад НДС-ын орлогоос үйл ажиллагаанд зарцуулах зардлын хувь, хэмжээ, хязгаарыг орлоготой уялдуулан тогтоож, үйл ажиллагааны зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлт тавих хяналтыг сайжруулах шаардлагатай. | 1 | - | | | 1 | - |
| Дүн | 1 | - | - | - | 1 | - |